

Аймгийн Засаг даргын... оны... дугаар  
сарын 10-ны өдрийн 12:00 дугаар захирамжийн  
хавсралт

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ  
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ

1220100005  
ТУ32325 9051449

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, орон нутагт хэрэгжүүлэхээр гаргасан бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт байгууллага, орон нутгийн өмчтэй хуулийн этгээд, сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, /цаашид “захиргааны байгууллага” гэх/-ын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх, шагнаж урамшуулах, хариуцлага тооцохтой холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь төрийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

1.3. Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журам болон энэхүү журмын дагуу хэрэгжүүлнэ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим

2.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд дараах зарчмыг баримтална:

2.1.1. Шударга, хараат бус байх;

2.1.2. Үйл ажиллагаа нээлттэй, тэдгээрээс гаргасан тайлан, дүгнэлт нь ил тод, нотлогдохуйц байх;

2.1.3. Шалгуур үзүүлэлт, тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;

2.1.4. Хяналт-шинжилгээг тасралтгүй, үнэлгээг тогтмол, тодорхой үе шаттай хийдэг байх;

2.1.5. Хэрэглэгч, оролцогч болон олон нийтийн оролцоог хангасан байх;

2.1.6. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгагдсан мэдээллийн үнэн зөв байдлыг холбогдох захиргааны байгууллага, албан тушаалтан хариуцдаг байх.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ

3.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрт дараах баримт бичиг хамаарна:

3.1.1. Монгол Улсын хууль;

3.1.2. Улсын Их Хурлын тогтоол;

3.1.3. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол;

3.1.4. Ерөнхийлөгчийн зарлиг;

- 3.1.5. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр;
  - 3.1.6. Засгийн газрын тогтоол;
  - 3.1.7. Ерөнхий сайдын захирамж;
  - 3.1.8. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл;
  - 3.1.9. Засгийн газрын болон ерөнхий сайдын албан даалгавар;
- 3.2. Бодлогын баримт бичигт дараах баримт бичиг хамаарна:
  - 3.2.1. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;
  - 3.2.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр;
  - 3.2.3. Төрөөс баримтлах бодлого;
  - 3.2.4. Үндэсний хөтөлбөр;
  - 3.2.5. Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;
  - 3.2.6. Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр;
  - 3.2.7. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө;
  - 3.2.8. Дэд хөтөлбөр, тусгайлан гаргасан бодлого, хөтөлбөр;
  - 3.2.9. Төсөл, хөтөлбөр;
- 3.3. Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд:
  - 3.3.1. Энэхүү журмын 3.1, 3.2-т заасан баримт бичгийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа;
  - 3.3.2. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт;
  - 3.3.3. Аймгийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, албан даалгаврын биелэлт;
  - 3.3.4. Ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа;
  - 3.3.5. Аймгийн Засаг даргаас Сумын Засаг дарга, агентлаг, төсөвт байгууллагын дарга нартай байгуулсан гэрээний үүргийн биелэлт;
  - 3.3.6. Хэрэглэгчийн үнэлгээний тайлан;
  - 3.3.7. Цаг үеийн асуудлаар өгсөн үүргүүдийн биелэлт;
  - 3.3.8. Стратеги төлөвлөгөөний биелэлт;
  - 3.3.9. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт;
  - 3.3.10. Шилэн дансны хөтлөлт;
  - 3.3.11. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт;

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлага, зохион байгуулалт

- 4.1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх, захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэх ажлыг

аймгийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, биелэлтэд нь хяналт тавих, мэдээлэх үүргийг хариуцна.

4.2. Энэ журмын 4.1-т заасан үүргийг тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд сумын Засаг дарга, байгууллага, аж ахуйн нэгжид дарга (захирал) нар тус тус хариуцна.

4.3. Захиргааны байгууллагын жилийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар томилон ажиллуулна.

4.4. Захиргааны байгууллагуудын жилийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ хооронд нь жишиж харьцуулах боломжоор хангах үүднээс ажлын хэсгийг нэг бүрэлдэхүүнээр зохион байгуулна.

4.5. Захиргааны байгууллага нь өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байна.

4.6. Төрийн албан хаагч нь хариуцсан чиг үүргийнхээ хүрээнд бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв, бодитойгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж эсхүл ажилтанд гаргаж өгөх үүрэгтэй.

4.7. Төр, орон нутгийн бодлого шийдвэр, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд үзүүлж буй иргэдийн сэтгэл ханамжийг тодорхойлох “Хэрэглэгчийн үнэлгээ” судалгааны ажлыг тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах зардлыг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардалд тусган батлуулсан байна.

4.8. Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг аймгийн Засаг даргын зөвлөлд жил бүрийн 02 дугаар сарын 10-ны дотор танилцуулж эцсийн дүнг гаргана.

4.9 Сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн зорилтолт түвшинг төлөвлөх, биелэлт, үр дүнг тооцох, тайлагнах үйл ажиллагааг сумын Засаг даргын орлогч хариуцна.

**Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтны эрх, үүрэг**

5.1. Байгууллагын дотоод нэгжүүдийн үйл ажиллагааны мэдээлэлтэй газар дээр нь танилцах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;

5.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамаарах мэдээлэл, баримт, материалыг холбогдох нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;

5.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтээр зөвлөмж өгөх, өгсөн зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцуулах тухай саналыг эрх бүхий албан тушаалтанд уламжлах;

5.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад олж авсан баримт, мэдээллийн нууцыг чанд хадгалж зөвхөн хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаанд ашиглах;

### Зургаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөлт, төрөл

6.1. Захиргааны байгууллагууд жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө хяналт шинжилгээ, үнэлгээний талаар тодорхой үйл ажиллагааг тусгах бөгөөд төлөвлөгөөнд зорилго, зорилт, хамрагдах байгууллага, нэгж, хэрэгжүүлэх хугацаа, зардал, хамтран оролцох байгууллага зэргийг тусгана

6.2. Хөндлөнгийн үнэлгээг явцын болон эцсийн үнэлгээний аль ч шатанд хийж болох бөгөөд иргэд, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж болно.

6.3. Төлөвлөгөөт бус хяналт-шинжилгээ, үнэлгээг иргэн, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээллийн дагуу болон хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр хийнэ.

6.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ шалгуур үзүүлэлт, тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслэхийн зэрэгцээ асууж танилцах, бодит ажлыг нүдээр үзэх, иргэдийн санал бодлыг сонсох, хяналтын болон асуулгын хуудас бөглүүлэх зэрэг үнэлгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

### Долоо. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

7.1. Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дараах аргачлалын дагуу хувиар илэрхийлэн үнэлнэ;

$$\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} \cdot 100\%$$

7.2. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанаар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг тодорхойлоход дараах аргачлалаар тооцно:

7.3. Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь;

7.4. Тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол 70.0 хувь;

7.5. Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол 50.0 хувь;

7.6. Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол 30 хувь;

7.7. тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийг "0" хувь.

7.8. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг энэ журмын 7.1-т заасан аргачлалын дагуу тооцож, зорилт, арга хэмжээний дундаж

үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг дараахь ангилалд шилжүүлэн тооцно;

7.8.1 “үр дүнтэй”-зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь;

7.8.2 “тодорхой үр дүнд хүрсэн”-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70-99 хүртэл хувь;

7.8.3 “эрчимжүүлэх шаардлагатай”-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай бол 31-69 хүртэл хувь;

7.8.4. “үр дүнгүй”-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 0-30 хүртэл хувь.

7.9. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийн үнэлгээг дараах аргачалаар тооцно:

7.9.1. “бүрэн хэрэгжсэн”-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);

7.9.2. “хэрэгжих шатанд”-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол 70 хувь (50-89 хүртэл хувь);

7.9.3. “хэрэгжилт хангалтгүй”-тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй бол 30 хувь (10-49 хүртэл хувь);

7.9.4. “хэрэгжээгүй”-тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа, бэлтгэл ажил хийгдэж боловсруулалтын шатанд байгаа болон тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 хувь (0-9 хүртэл хувь);

7.9.5. “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”.

7.10. Бодлогын баримт бичгийн зорилго, зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн ерөнхий дүнг гаргахдаа зорилт, арга хэмжээ, зүйл, заалт бурийн хэрэгжилтийн арифметик дунджаар тооцно.

7.11. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хоёр удаагийн тайлангийн хугацаанд дараалан ахиц гараагүй бол удааширан, гурван удаагийн тайлангийн хугацаанд мөн ахиц гараагүй бол тасарсанд тооцно.

7.12. Засгийн газрын гишүүнээс аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт, стратеги төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхдээ бодлогын баримт бичиг үнэлэх аргачлал, байгууллагын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааг үнэлэхдээ хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ тооцдог аргачлалыг тус баримтална.

7.13. Бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, сүүлийн 3 жил тасарсан болон тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан хууль тогтоомж, тогтоол, захирамж шийдвэрийн заалтыг хүчингүй болгох, хяналтаас хасах тухай саналыг жилийн эцсийн тайлангийн хамт хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлнэ.

7.14. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр тухайн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх хугацааны эхний хагаст шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшний 30 хүртэл хувийг хангаагүй, жилийн эцсийн үнэлгээгээр санхүүгийн эх үүсвэргүй нь тогтоогдсон, үр дүнгүй, үнэлэх боломжгүй гэж үзсэн зорилт, арга хэмжээг цаашид үргэлжлүүлэх эсэхийг тухайн бодлогын баримт бичгийг баталсан эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлнэ.

7.15. Энэхүү журмын 3.1, 3.2, 3.3-т заасан бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн тайланг мөн журмын 2 - 13 дугаар хавсралтын дагуу гаргаж, журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлнэ.

7.16. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тухайн захиргааны байгууллагын үйл ажиллагаатай холбоотой болон нийтлэг хэм, хэмжээ тогтоосон шийдвэрүүдийн холбогдох заалт бүрийг хяналтад авч, хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.

7.17. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, аймгийн Засаг даргын Тамгын газарт журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд хүргүүлнэ.

7.18. Аймгийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, шийдвэрийн тухайн сум, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой болон ажил хэргийн шинж чанартай, нийтээр дагаж мөрдөх тогтоол шийдвэрийн заалт тус бүрийн хэрэгжилтийг нь үнэлж, нэгдсэн үнэлгээг өгнө.

7.19. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээг энэхүү журмын 11 дүгээр хавсралтын дагуу гаргаж, тогтоосон хугацаанд Аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

7.20. Цаг үеийн асуудлаар өгөгдсөн үүргийн биелэлтийг тооцохдоо тухайн жилд тусгайлан хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай, ажил, арга хэмжээний гүйцэтгэл үр дүнгээр тооцно.

7.21. Хэрэглэгчийн үнэлгээг төр засгийн болон орон нутгийн бодлого шийдвэрийн хэрэгжилт, захиргааны байгууллагаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийн түвшинг тодорхойлох зорилгоор аймгийн Засаг даргын тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу хөндлөнгийн байгууллагаар хийлгэнэ.

7.22. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмыг үндэслэнэ.

7.23. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн тухайн жилийн зорилтыг шалгуур үзүүлэлтийн дагуу төлөвлөж 4 сарын 1-ний өдрийн дотор аймгийн Засаг даргын тамгын газраар батлуулна.

7.24. Сум нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн зорилtot түвшинг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсан өдрөөс хойш 3 сарын дотор бүрэн эрхийн хугацаагаар тооцон боловсруулж аймгийн Засаг даргын Тамгын газраар батлуулна.

7.25. Захиргааны байгууллага нь тусгай удирдамжийн дагуу ажлын хэсэг гарган өөрийн дотоод үйл ажиллагаандаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргаж ажиллана.

7.26. Тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Сумдын Засаг дарга, түүний Тамгын газар нь энэхүү журмын 2 дугаар хавсралтын дагуу, агентлаг, төсөвт байгууллагууд энэхүү журмын 3 дугаар хавсралтын дагуу гаргаж, тайланг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлнэ.

7.27. Тайлан бүрийн гүйцэтгэлийг сумын Засаг даргын Тамгын газрын дарга, захиргааны байгууллагын дарга, хянаж баталгаажуулсан байна.

7.28. Хэрэгжилтийн тайланг бичихдээ тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаах бөгөөд шаардлагатай бол нотлох баримтыг файлаар хавсаргаж болно.

7.29. Эдийн засгийн үзүүлэлт, зорилtot түвшний үнэлгээг тооцоходо тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааны бодит гүйцэтгэлийг урьдчилан тодорхойлсон зорилtot түвшинд харьцуулна.

7.30. Ажилчдын үнэлгээ гэж тухайн байгууллагын үйл ажиллагааны талаар байгууллагын ажилтан албан хаагчдаас санал асуулгын хуудсаар авсан үнэлгээний дунджийг хэлнэ.

7.31. Сумын Засаг дарга нь энэхүү журмын 16 дугаар хавсралтад заасан нийтлэг шалгуур үзүүлэлтээр багийн үйл ажиллагааг үнэлж дүгнэнэ.

7.32. Бодлогын зорилт, арга хэмжээний төлөвлөлт, төсөвлөлт, тайлагналт, хэрэгжилтийн харилцан хамаарлын үнэлэх арга зүй:

7.32.1. "Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль"-ийн 5 дугаар зүйл (Хөгжлийн бодлого, төлөвлөлтэд баримтлах зарчим)-д нийцүүлэн төлөвлөөгүй бол сул төлөвлөлт гэж үзэн хэрэгжилтийн үнэлгээг 20 хувиар бууруулна.

7.32.2. Тайланд тавигдах шаардлагад нийцүүлэн тайлагнаагүй бол тайлангийн чанар муу гэж үзэн хэрэгжилтийн үнэлгээг 20 хувиар бууруулна.

7.32.3. Дээрх хоёр алдаа нэг зорилт, арга хэмжээний төлөвлөлт, тайлагналт дээр зэрэг гарсан бол хэрэгжилтийн үнэлгээг 40 хувиар бууруулахгүй, 20 хувиар бууруулна.

7.32.4. Засгийн газрын 2020 оны 217, 218 дугаар тогтоолоор баталсан журмууд, ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 тоот тушаалаар баталсан аргачлалын дагуу байгууллага, нэгж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлээгүй бол хэрэгжилтийн үнэлгээг 20 хувиар бууруулна.

7.32.5. Тухайн бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг шууд уялдаатай хөгжлийн үзүүлэлтийн өөрчлөлттэй харьцуулан 20 хувиар өсгөж, бууруулж болно. Шууд уялдаатай хөгжлийн үзүүлэлт нь:

- а. Албан ёсны болон захиргааны статистик мэдээллийн өөрчлөлт;
- б. Орон нутгийн болон сумын хөгжлийн индексийн өөрчлөлт;
- в. Аймаг, сум, байгууллагын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт байна.

7.32.6. Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас хэрэгжүүлэх боломжгүй болсон бол хэрэгжилтийг үнэлэхгүй байж болно.

7.32.7. Баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнахдаа хугацаа хоцроосон бол тухайн байгууллагын жилийн үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээг 2 хувиар бууруулна.

7.32.8 Баримт бичгийн хэрэгжилтийг Засаг даргын зөвлөл, агентлагийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээгүй бол тухайн байгууллагын жилийн үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээг 2 хувиар бууруулна.

Найм. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг хэрэгжүүлэх, урамшуулах

8.1. Ерөнхий үнэлгээгээр үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг:

90.00% - аас дээш	“A” - “ҮР ДҮНТЭЙ”
70.00% - 89.99% хүртэл	“B” - “ТОДОРХОЙ ҮР ДҮНД ХҮРСЭН”
51.00% - 69.99% хүртэл	“C” - “ЭРЧИМЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ”
31.00% - 50.99% хүртэл	“D” - “ҮР ДҮНГҮЙ”
00.00% - 30.99% хүртэл	“F” - “ХАНГАЛТГҮЙ”

8.2. Захиргааны байгууллагыг жилийн үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр нь шалгаруулан дараах байдлаар шагнаж, урамшуулна.

8.2.1. Сум:

1-р байр - “Аймгийн тэргүүний сум” батламж, 5 сая төгрөг, сумын Засаг даргыг сарын үндсэн цалингаар,

2-р байр - Батламж, 3 сая төгрөг, сумын Засаг даргыг 1 сарын үндсэн цалингийн 75 хувиар,

3-р байр - Батламж, 2 сая төгрөг, сумын Засаг даргыг 1 сарын үндсэн цалингийн 50 хувиар,

### **8.2.2. Агентлаг:**

1-р байр – “Аймгийн тэргүүний байгууллага” өргөмжлөл, 3 сая төгрөг, даргыг сарын үндсэн цалингаар,

2-р байр – өргөмжлөл, 2 сая төгрөг, даргыг 1 сарын үндсэн цалингийн 75 хувиар,

3-р байр – өргөмжлөл, 1 сая төгрөг, даргыг 1 сарын үндсэн цалингийн 50 хувиар тус тус шагнаж урамшуулна.

### **8.2.3. Төсөвт байгууллага:**

1-р байр - Өргөмжлөл, 1 сая төгрөгөөр шагнаж, даргад 1 сарын үндсэн цалингаар,

### **8.2.4. Орон нутгийн өмчит байгууллага:**

1-р байр - Өргөмжлөл, 1 сая төгрөгөөр шагнаж, даргад 1 сарын үндсэн цалинтай тэнцэхүйц хэмжээний урамшуулал тус тус олгоно.

8.2.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр эхний байруудад шалгарч, шагнагдсан захиргааны байгууллага нь хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж эсхүл ажилтныг ажлын үр дүнг харгалзан үндсэн цалингийн 75 хүртэл хувиар урамшуулна.

8.3. Тухайн жилийн үнэлгээний дүнгээр “А”-Үр дүнтэй”, “В”-“Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлэгдсэн сум, агентлаг, төсөвт байгууллага гараагүй тохиолдолд энэхүү журамд заагдсан урамшуулал, шагналыг олгохгүй.

8.4. Шагналд зарцуулах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сан, цалингийн урамшууллыг тухай байгууллагын төсвөөс гаргана.

### **8.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг олон нийтэд ил тод мэдээлнэ.**

### **Ес. Хариуцлага**

9.1. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны үнэлгээний дүнгээр хоёр удаа хангалтгүй үнэлгээ авсан, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт нь буурсан агентлаг, төсөвт байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга болон сумын Засаг даргын Тамгын газрын даргыг Төрийн албаны тухай хуулийн 23.1-д заасны дагуу албан тушаал бууруулах саналыг эрх бүхий албан тушаалтанд уламжилна.

9.2. Тухайн жилдээ ажлын үзүүлэлтээр “Эрчимжүүлэх шаардлагатай”, “Үр дүнгүй” үнэлгээ авсан хэлтэс, агентлагийн дарга, сумдын Засаг даргын мэдээллийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

9.3. Дараах зөрчил гаргасан албан тушаалтанд Төрийн албаны тухай, Төсвийн тухай болон холбогдох бусад хуульд зааснаар хариуцлага хүлээлгэнэ:

- 9.3.1. тайлан ирүүлээгүй болон худал, зэрүүтэй мэдээллээр тайлагнасан;
- 9.3.2. өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй;
- 9.3.3. хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, тайланг Засаг даргын зөвлөл болон байгууллагын дарга /захирал/-ын хурлаар хэлэлцүүлээгүй.
- 9.3.4. Тайланг хугацаанд нь ирүүлээгүй

-----o0o-----

Журмын 1 дүгээр хавсралт

БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН  
ХЭРЭГЖИЛТ, БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАЙЛАГНАХ ХУГАЦАА

№	Тайлангийн төрөл	ХШҮ, нэгтгэл хийх байгууллага	Тайлан хүргүүлэх хугацаа	Тайлан хүлээн авах нэгж, байгууллага	Тайлбар	Давтамж
1	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	Агентлаг	1 сарын 5 6 сарын 20	АЗДТГ-ын нэгжүүд		жил бүр
		АЗДТГ-ын хэлтэс	1 сарын 10 6 сарын 25	ТЗУХ		
		ТЗУХ	1 сарын 15 7 сарын 1	ХШУДАХ		
		ХШУДАХ	2 сарын 1, 7 сарын 10	ЗГХЭГ		
2	Үндэсний хөтөлбөр	Агентлаг	1 сарын 10	АЗДТГ-ын нэгжүүд		жил бүр
		АЗДТГ-ын хэлтсүүд	2 сарын 10	Холбогдох яам		
3	Төрөөс баримтлах бодлого	Агентлаг	1 сарын 5	АЗДТГ-ын нэгжүүд		Жил бүр
		АЗДТГ-ын хэтсүүд	2 сарын 1	Холбогдох яам		
4	Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Агентлаг	1 сарын 5	ХОХБТХ		Жил бүр
		Бодлогын хэлтэс	2 сарын 1	Үндэсний хөгжлийн газар		
5	Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Агентлаг	1 сарын 5	ХОХБТХ		Жил бүр
		ХОХБТХ	1 сарын 20	Үндэсний хөгжлийн газар	ИТХ-аар хэлэлцүүлнэ	
6	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	Агентлаг, сум	1 сарын 10	ТЗУХ	ИТХ-д танилцуулна	жил бүр
		ТЗУХ	1 сарын 25	ХШУДАХ		
		ХШУДАХ	2 сарын 20	ЗГХЭГ		
7	Аймгийн дэд хөтөлбөр	Агентлаг, сум	1 сарын 10	АЗДТГ-ын нэгжүүд		
		АЗДТГ-ын хэлтэс	1 сарын 25	ХШУДАХ		
		ХШУДАХ	2 сарын 20	ЗГХЭГ		
8	Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	Сумд	1 сарын 5	ХШУДАХ	ИТХ-д танилцуулна	жил бүр
		ХШУДАХ	2 сарын 1	Аймгийн ИТХ	Аймгийн ИТХ-д танилцуулна	
9	Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө	Агентлаг, сум	1 сарын 10	АЗДТГ-ын нэгжүүд		жил бүр
		Бодлогын хэлтэс	1 сарын 15	ХОХБТХ	Аймгийн ИТХ-д танилцуулна	
		ХОХБТХ	1 сарын 25	ХШУДАХ		
		ХШУДАХ	2 сарын 20	ЗГХЭГ		

10	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	Агентлаг	12 сарын 20 6 сарын 10	ТЗУХ		жил бүр
		ТЗУХ	12 сарын 30 6 сарын 15	ХШУДАХ		
		ХШУДАХ	1 сарын 15 7 сарын 1	ЗГХЭГ		
11	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт	Агентлаг, сум	1 сарын 10	АЗДТГ-ЫН нэгжүүд		Жил бүр
		Бодлогын хэлтэс	2 сарын 1	Холбогдох яам		
12	Стратеги төлөвлөгөөний биелэлт	Агентлаг	6 сарын 30	АЗДТГ-ЫН нэгжүүд		2 жил тутам
		Бодлогын хэлтэс	2 сарын 20	ХОХБТХ		4 жилд
		ТЗУХ	3 сарын 10	ХШУДАХ		
		ХШУДАХ	4 сарын 1	ЗГХЭГ		
13	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	Агентлаг	12 сарын 10	ХШУДАХ		Жил бүр
		Бодлогын хэлтэс	2 сарын 1	ТЗУХ		
		ТЗУХ	2 сарын 20	ХШУДАХ		
		ХШУДАХ	4 сарын 1	ЗГХЭГ		
14	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт;	Агентлаг, сум	2 сарын 15	ТЗУХ		Жил тутам
		ТЗУХ	3 сарын 15	ХШУДАХ		
		ХШУДАХ	4 сарын 1	ЗГХЭГ		
15	Тухайн жилийн үйл ажиллагааны хяналт- шинжилгээ, үнэлгээний тайлангууд	Агентлаг, сум	1 сарын 10	ХШУДАХ		Жил тутам
		ХШУДАХ	4 сарын 1	ЗГХЭГ		

Журмын 2 дугаар хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГ, ТӨСӨВТ  
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

(... оны үйл ажиллагааны үр дүн)

	Үзүүлэлт	Хэрэг жилтийн хувь
Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	<ol style="list-style-type: none"> <li>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт</li> <li>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт</li> <li>Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт</li> <li>Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт</li> </ol>	
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	<ol style="list-style-type: none"> <li>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт</li> <li>Аймгийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, албан даалгаврын биелэлт</li> <li>Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт</li> <li>Цаг үеийн асуудлаар өгсөн үүргийн биелэлт</li> <li>Байгууллагын ил тод байдал, шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ</li> </ol>	
Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	<ol style="list-style-type: none"> <li>Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ</li> <li>Хэрэглэгчийн үнэлгээ</li> </ol>	
Ерөнхий үнэлгээ		

Журмын 3 дугаар хавсралт

СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

(... оны үйл ажиллагааны үр дүн)

Үзүүлэлт		Байгуул лагын үнэлгээ
Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 3. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт 4. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт 2. Аймгийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, албан даалгавар, биелэлт 3. Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн 4. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт 5. Цаг үеийн асуудлаар өгсөн үүргийн биелэлт 6. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ, шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	
Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	1. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ 2. Агентлагуудаас өгсөн үнэлгээ 3. Хэрэглэгчийн үнэлгээ	
Ерөнхий үнэлгээ		

Журмын 4 дүгээр хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

(... оны үйл ажиллагааны үр дүн)

	Үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь
Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	<ol style="list-style-type: none"><li>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт<ul style="list-style-type: none"><li>- Үндсэн чиг үүргийн хүрээнд дагаж мөрддөг хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүд</li><li>- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль</li></ul></li><li>Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ</li></ol>	
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	<ol style="list-style-type: none"><li>Аймгийн Засаг даргатай байгуулсан контрактын үүргийн биелэлт</li><li>Аймгийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, албан даалгаврын биелэлт</li><li>Цаг үеийн асуудлаар өгсөн үүргийн биелэлт</li><li>Байгууллагын ил тод байдлын үнэлгээ, шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ</li></ol>	
Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	<ol style="list-style-type: none"><li>Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний үнэлгээ</li><li>Хэрэглэгч болон ажилчдын үнэлгээ</li></ol>	
Ерөнхий үнэлгээ		

Журмын 5 дугаар хавсралт

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар,	Заалтын агуулга	Хэрэгжилт /Тасарсан болон удааширч байгаа шалтгаан/	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)
Салбар чиглэл: 1					
1.а. Монгол Улсын хууль					
1.б. Улсын Их Хурлын тогтоол					
1.в. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол					
1.г. Ерөнхийлөгчийн зарлиг					
1.д. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл					
1.е. Засгийн газрын тогтоол					
1.ё. Ерөнхий сайдын захирамж					
1.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл					
1.з. Засгийн газрын албан даалгавар					
Хэсгийн дундаж: ..... хувь					
Салбар чиглэл: 2					
2.а. Монгол Улсын хууль...					
Хэсгийн дундаж: ..... хувь					
Нийт дундаж: ..... хувь					

Журмын 6 дугаар хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

№	Зорилт	№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа, хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, хэрэгжилт, тайлбар	Хэрэгжилтийн хувь
БҮЛЭГ							
1	1.1.1 ...	1					
2		2					
3	1.1.2 ...	1					
4		2					

Журмын 7 дугаар хавсралт

АЙМГИЙН /СУМЫН/ ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН  
БИЕЛЭЛТ

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа, хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, хэрэгжилт, тайлбар	Хэрэгжилтийн хувь
БҮЛЭГ ..							
1		1.1. ....	1.1.1. ....				
2			1.1.2....				
3		1.2. ....	1.2.1				
4							

Журмын 8 дугаар хавсралт

АЙМГИЙН ИТХ-ЫН ТОГТООЛ, ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ ШИЙДВЭРИЙН  
БИЕЛЭЛТ

№	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хяналтад авсан заалт	Хэрэгжилт / Хэрэгжээгүй бол шалтгаан, нөхцөл байдал/	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)
Нэг: ИТХ-ын тогтоол				
1				
2				
3				
Хоёр: Аймгийн Засаг даргын захирамж				
1				
Гурав: Аймгийн Засаг даргын албан даалгавар				
1				

Журмын 9 дүгээр хавсралт

**БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь тувшин	Зорилтот түвшин /жилийн эцэс/	Хүрсэн тувшин	Хэрэгжилт тайлбар /хэрэгжээгүй бол шалтгаан/	Гүйцэтгэлийн хувь
